



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№40 /484/

2023.03.07

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН СЭТГҮҮЛЧДЭД БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЭВ



МЭНДЧИЛГЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦИЙН ХАМТ ОЛОНД

Монгол Улсад Үндэсний сэтгүүл зүй үүсч хөгжсөний 110 жилийн ойн баярыг тохиолдуулан 100 жилийнхээ буурал түүхийг 2024 онд тэмдэглэн өнгөргүүлэх Монгол Улсын ууган хэвлэлийн нэг "Соёмбо" сонины үе үеийн сэтгүүлч, уран бүтээлчдэд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нийт бие бүрэлдэхүүний нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлэе!

Цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг үзгээрээ дархлаажуулагч, үйлдлээрээ мөнхжүүлэхийн зэрэгцээ ард түмэндээ цэрэг дайчдаа алдаршуулагч, дарцаглах туг нь болон гялалзаж яваа "Соёмбо" редакцын хамт олонд бичиж туурвих, түгээж нэвтрүүлэх их үйлсэд тань өндөр амжилт хүсье!

Үг нь мэргэн, үзэг нь хурц байх болтугай!

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН ХАМТ ОЛОНД
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ч.ЦОГТЖАРГАЛ

УКА 0080
11171 4507 6130955
2023.03.06

Өнөөдөр Монгол Улсад Үндэсний сэтгүүл зүй үүсэж хөгжсөний 110 жилийн ойн тохиож байна. Түүхт ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг гүйцэтгэж яваа цэргийн сэтгүүлч, уран бүтээлчдэд баярын мэндчилгээ дэвшүүлэв.

Мэндчилгээнд "Монгол Улсад Үндэсний сэтгүүл зүй үүсэж хөгжсөний 110 жилийн ойн баярыг тохиолдуулан 100 жилийнхээ буурал түүхийг 2024 онд тэмдэглэн өнгөрүүлэх Монгол Улсын ууган хэвлэлийн нэг "Соёмбо" сонины үе үеийн сэтгүүлч, уран бүтээлчдэд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нийт бие бүрэлдэхүүний нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлэе. Цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг үзгээрээ дархлаажуулах, үйлдлээрээ мөнхжүүлэхийн зэрэгцээ ард түмэндээ цэрэг дайчдаа алдаршуулагч, дарцаглах туг нь болон гялалзаж яваа "Соёмбо" редакцын хамт олонд бичиж туурвих, түгээж нэвтрүүлэх их үйлсэд тань өндөр амжилт хүсье! Үг нь мэргэн, үзэг нь хурц байх болтугай" гэжээ.

Мөн Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдыг сурвалжилж сурталчлахад идэвх санаачилгатай ажиллаж байгаа тус редакцын залуу сэтгүүлч Ө.Насантогтоход талархал гардуулж, мөнгөн шагналаар шагнасан юм.

ТЕННИСНИЙ ШИРЭЭГ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ



Монгол цэргийн нэгдсэн холбооны АНУ дахь салбар хорооны тэргүүн М.Баасанжав санаачилгаар ҮБХИС-ийн харьяа Нийслэлийн ерөнхий боловсролын "Тэмүүжин өрлөг" сургууль болон Батлан хамгаалахын төв архивын материаллаг баазыг бэхжүүлэх замаар ажилтан алба хаагч болон хүүхэд залуусын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2 сая төгрөгийн үнэ бүхий теннисний ширээг хүлээлгэн өглөө. Тус үйл ажиллагаанд

Тэмүүжин өрлөг сургуулийн захирал хурандаа Д.Бат-Эрдэнэ, МЦНХ-ны АНУ дахь салбар холбооны нарийн бичгийн дарга З.Эрдэнэбат, Удирдах зөвлөлийн гишүүн Ё.Бямбадорж, Д.Будсүрэн нар оролцлоо.

МӨРДЭСТЭЙ БҮСГҮЙЧҮҮД ЧУУЛАВ

Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс "Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтан Өмнөговь аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэйчүүдийн дунд "Мөрдөстэй бүсгүйчүүд" анхдугаар чуулга уулзалтыг зохион байгууллаа.

Тус чуулга уулзалт нь цэрэг-эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, Даланзадгад цэргийн хүрээний болон хууль сахиулах байгууллагад ажиллаж буй эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, тэдний хамтын ажиллагааг дээшлүүлэх, цэргийн шинэчлэл, манлайлалд эмэгтэйчүүдийн оролцоог идэвхжүүлэхэд чиглэсэн юм.

Уулзалтаар Өмнөговь аймаг дахь Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүн Г.Өлзийбүрэн, Даланзадгад сумын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Д.Гантуяа тэргүүтэй бүсгүйчүүд олон сонирхолтой илтгэл хэлэлцүүлгийг өрнүүлсний зэрэгцээ "Аз жаргалын эхлэл", "Ажил амьдралыг тэнцвэржүүлэх нь", "Гэр бүлийн нандин харилцаа" зэрэг сэдвээр сургалт зохион байгууллаа.

Ахлах дэслэгч Б.БАТЗАЯА



ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 3	☁️ -6
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	☁️ 24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,532	3,535
EUR 🇪🇺	3,767	3,780
CNY 🇨🇳	512.50	514
RUB 🇷🇺	45.80	46.20
JPY 🇯🇵	26.20	26.45
KRW 🇰🇷	2.72	2.74

ЗУРХАЙ



ХАВРЫН ТЭРГҮҮН ХӨХ БАР САР
ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ХӨХ ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:
Өлзийтэй сайн
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.22-18.44
Барилдлага:
Арвидах
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Хүрэлцэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэйЭл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 680,732,738
Эдгэрсэн
Нийт: 653,626,275
Нас барсан
Нийт: 6,805,594

Цахим шууданд

ХУГАЦААТ ЦЭРГҮҮД ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МУЗЕЙД ЗОЧИЛОО



"Музейн нээлттэй хаалганы өдөр"-ийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид Өвөрхангай аймгийн музейгээр зочиллоо. Энэ үеэр Өвөрхангай аймгийн музейн эрдэм шинжилгээний ажилтан Б.Бат-Эрдэнэ дайчдад өгсөн мэдээлэлдээ "Тухайн нутаг орны онцлог, түүх, соёл, бахархал зэргийг музейн үзмэрүүдээс төвөггүй мэдэж болно. Өвөрхангай аймгийн музей нь 1951 онд Гэгээрлийн хэлтсийн

дэргэд "Сургалтын арга зүйн кабинет" нэртэйгээр 200 гаруй үзмэртэйгээр байгуулагдаж, 1966 онд "Орон нутаг судлах кабинет" болон өргөжсөн. 1993 оноос музейн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж зөвхөн орон нутаг судлах төдийгөөр хязгаарлагдах бус сургалт, танин мэдэхүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах болсныг онцлоод музей нь дотроо байгаль, газар зүй, ан амьтан, эртний түүх, угсаатны зүй, сийлбэр, алдар гавьяатан, цэргийн гэсэн долоон

танхимаас бүрддэг. Мөн өндөр гэгээн Занабазарын болон Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн салбар музейтэй. Энд тухайн хүмүүсийн намтар, уран бүтээл, эдэлж хэрэглэж явсан эд зүйл зэргийг харуулсан байдаг. Мөн бусад аймгаас ялгарах онцлог нь сийлбэрийн танхим. Өвөрхангайчууд сийлбэр урлалаараа алдартай учир бид хүндэтгэн байрлуулсан" хэмээн тодотгож байсан юм.

Ахлах дэслэгч Т.АЛТАНТУУЛ

УРАН УНШЛАГА НЬ ХҮНИЙ МЭДРЭМЖ, СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛДЭГ



Зэвсэгт хүчний 186 дугаар ангийнхан "Алба, салбараа сурталчлах ажил"-ын хүрээнд "Найраглал, уран уншлага"-ын тэмцээнийг Орхон аймгийн Төв номын сантай хамтран зохион байгууллаа. Уг тэмцээнд 12 багийн 24 цэргийн алба хаагч оролцож цэрэг-эх орны шүлэг, найраглалыг уншин

өрсөлдсөнөөс ахмад Я.Очирбат даргатай баг тэргүүн байр, ахлах дэслэгч Б.Золбаяр даргатай баг дэд байр хошууч Н.Алтангэрэл даргатай баг гутгаар байр эзэлсэн бол шилдэг уншигчаар Т.Содном шалгарч бусад нөхдөө манлайллаа. Энэ үеэр тэмцээний шүүгч, Орхон аймгийн Төв номын сангийн дарга Д.Цэнд-Аюуш

хэлсэн үгэндээ "Уран уншлагыг зохион байгуулахын зорилго нь цэрэг-эх орны сэдэвтэй яруу найргаар дамжуулан өөрсдийн залуу нас, ажил амьдралаа эх орноо батлан хамгаалах ариун үйлсэд зориулсан ахмад үеэ хүндэтгэн хайрлах зэрэг зөв ёс суртахууныг түгээхэд чиглэлээ. Яруу найргаар дамжуулж хүний сэтгэлийг хөглөгддөг, түүгээр дамжуулж илэрхийлсэн гүн утгаар хүмүүс хоорондоо хайрыг дамжуулдаг, соёлыг төлөвшүүлдэг" хэмээсэн юм

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ



Гэрэл зураг-нэг агшин



Тэнгэр нь цэлмэг
Тазар нь зөвлөн байг

ҮБХИС-ИЙН ЭРДМИЙН СУРГУУЛИЙН "ЭРДЭМ СУДЛАЛ-2023" МАГИСТРАНТ, ДОКТОРАНТУУДЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ХҮРЭЛЦЭН ИРЭХИЙГ УРЬЖ БАЙНА

СЭДЭВ: "ЭРДЭМ СУДЛАЛ-2023"

Зорилго: Магистрант, докторантууд өөрсдийн сонгосон сэдвийн хүрээнд судалгааны ажлын үр дүнгээ хэлэлцүүлэх, судалгааны ажлыг эрчимжүүлэх, арга туршлагаа харилцан солилцох боломжийг олгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга зүйд суралцахад оршино.

Илтгэл хүлээн авах хугацаа:

- Илтгэлийг цахимаар 2023 оны 03 дугаар сарын 03-аас 03 дугаар сарын 16-ны өдрүүдэд хүлээн авна.

Цахимаар хүлээж авах E-mail: Магистрантууд: ch.boldbaatar.63@gmail.com 88286325

Хамрах хүрээ: Магистрант, докторантууд

Хугацаа: "Эрдэм судлал 2023" магистрант, докторантуудын эрдэм шинжилгээний бага хурал 2023 оны 3 дугаар сарын 21-нд Сүбээдэй танхимд болно.

Илтгэлд тавигдах шаардлага: ҮБХИС-ийн стандартын дагуу бичнэ.

- Илтгэл нь эрдэм шинжилгээний ажлын удирдагч, эсвэл тухайн мэргэжлийн чиглэлийн эрдэмтнээр хянан баталгаажуулсан байна;

- Өгүүллийн нэр; /12pt өндөртэй үсгээр, мөр хоорондын зай 1 байхаар, тод (Bold), том (Caps Lock) үсгээр голлуулсан бичнэ./

- Зохиогчийн овог, нэр; (12pt өндөртэй үсгээр, налуу (Italic) форматаар мөр голлон бичнэ.

- Хураангуй; /15 мөр, 150-250 үгэнд багтааж бичнэ. 11pt өндөртэй үсгээр, italic форматтай бичигдэнэ./

- Түлхүүр үг; /3-5 түлхүүр үг хэрэглэнэ. 11pt өндөртэй үсгээр, italic форматтай бичигдэнэ.

- Судалгааны ажлын үндсэн хэсэг /Өгүүллийг Arial фондоор, мөр хоорондын зай 1,15 байхаар, А4 хэмжээний цаасан дээр зүүн гар талаас 30 мм, баруун гар талаас 15 мм, дээд, доод талаас 20 мм-ийн зай авч бичнэ. Өгүүллийг 10 хүртэлх хуудсанд багтаан бичнэ./

- Дүгнэлт.

- Өгүүлэлд ашигласан эх сурвалжаас заавал эш татна. Эш татсан эх сурвалжийг бичвэрийн холбогдох хэсэгт зүүлт эшлэлийн аргаар (insert footnote) хуудасны доод хэсэгт оруулна. Эшлэлийн эх сурвалжид зохиогч, эх сурвалжийн нэр, хэвлэгдсэн улс, хот, хэвлэгдсэн он, хэвлэгдсэн газар, хэмжээ (хуудасны тоо), хуудасны дугаар/тал, ISBN-ын дугаар зэргийг дэс дараалуулан бичнэ.

ҮБХИС-ИЙН ЭРДМИЙН СУРГУУЛЬ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 353 ДУГААР АНГИЙН БАГ ТЭРГҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 353 дугаар ангиас Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан нийтийн биеийн тамирыг сурталчлах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилготой гар бөмбөгийн тэмцээнийг Налайх дүүргийн байгууллагуудын эмэгтэйчүүдийн дунд зохион байгууллаа. Тэмцээнд нийт 10 баг оролцсоноос тэргүүн байрт Зэвсэгт хүчний 353 дугаар анги, дэд байрт Политехникийн коллежийн багш нарын баг, гутгаар байрт Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн баг тамирчид тус тус шалгарлаа.

